



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 07 сарын 15 өдөр

Дугаар 34

Алтай

Хуралдааны тов тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдөр Алтай хотод хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгууль зохион байгуулсан дүнгийн тухай аймгийн Сонгуулийн хорооны мэдээлэл

2. Зохион байгуулалтын асуудал

А. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Б. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгож батлах тухай

В. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг сонгож батлах тухай

Г. Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай

3. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны дарга /Л.Болормаа/- үүрэг болгосугай

ДАРГА



А.ДЭЛГЭРЖАРГАЛ